

2024 оны 10 сарын 17 өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1, 92.2 дахь хэсэг, “Худалдаа, хөгжлийн банк” ХК (цаашид “Банк” гэх)-ийн дүрмийн 8 дугаар 8.11.20 дахь заалтыг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Банкны холбогдох этгээд болох дараах хуулийн этгээдүүдтэй Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулсан нөхцөлийн дагуу дараах сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг байгуулахыг зөвшөөрсүгэй.
 - 1.1. “Нэйшнл ньос корпорэйшн” ХХК-тай Түрээсийн гэрээ;
 - 1.2. “Ти Ди Би Капитал” ХХК-тай Түрээсийн нэмэлт гэрээ;
 - 1.3. “Ти Ди Би Секьюритис ҮЦК” ХХК-тай Түрээсийн нэмэлт гэрээ;
 - 1.4. “Аурум Металс” ХХК-тай Түрээсийн гэрээ.
2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээ, хэлцэл болон холбогдох бусад баримт бичигт Банкийг төлөөлөн гарын үсэг зурах, холбогдох этгээдэд дамжуулан итгэмжлэл олгох болон шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д олгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



РАНДОЛФ КОППА